



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/93

Арвайхээр сум

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийн дагуу Шаардлага хангасан сайжруулсан түлшний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх тендерийн 1 дүгээр багц Шахмал түлшний шуудай нийлүүлэх тендерийг 216,087,300 (хоёр зуун арван зургаан сая наян долоон мянга гурван зуу) төгрөгөөр Бодь мир ХХК-иар, 2 дугаар багц Барьцалдуулагч улаан буудай нийлүүлэх тендерийг 155,000,000 (нэг зуун тавин таван сая) төгрөгөөр Алхими ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.


2.Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3.Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т үүрэг болгосугай.

4.Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 3 дугаар багц Авто ачигч 3 метр куб шанагатай, 4 дүгээр багц Сэрээт авто ачигч, 5 дугаар багц Шахмал түлш түгээх машин, 6 дугаар багц Түлш шигшиж, жинлэж, савлах төхөөрөмж нийлүүлэх багцуудыг хүчингүй болгосугай.

5.Дээрх хүчингүй болсон багцуудыг хуулийн дагуу дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын эрхрэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ДАРГА



А.ИШДОРЖ